

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2019.02.25

СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТАЛААР:

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтанд мэргэжилтэн Н.Солонго, Т.Дашцэдэн, нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд нар хамрагдсан.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЛААР:

Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд нийт 32 байгууллагуудад мэдэгдэл хүргүүлсний дагуу 12 байгууллага Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ирүүлсний дагуу төлөвлөгөөтэй танилцаж 7 ААНБ-ын менежментийн төлөвлөгөөг баталсан. 5 ААНБ-ын менежментийн төлөвлөгөөг засаж сайжруулах зөвлөгөө өгөн буцаагаад байна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө 2018 онд тайлагнаагүй ААНБ –уудыг шалган зөрчлийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 2019 онд хэрэгжүүлэх ажлынхаа талаар орон нутгийн аялал жуулчлалын холбоо болон үйлчилгээ эрхлэгч нартай уулзаж хамтран ажиллах төлөвлөгөө гаргалаа.

АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАЛААР:

Хог хаягдалтай газрыг цэвэрлүүлж газар олгох журмын дагуу “ЦЕРКОН ГЕОЛОГИ” ХХК –ны Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт барилгын хог хаягдал бүхий 3 байрлалд хог цэвэрлэх ажлын гүйцэтгэлтэй танилцаж дутуу гүйцэтгэлтэй байгааг тогтоон үүрэг даалгавар өгч гүйцээн цэвэрлүүлэхээр тайланг буцаагаад байна.



Бусад ажлын талаар:

- Байгууллагын албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийн гэрээг байгуулан төлөвлөгөөг батлав.
- 2019 оны хөрөнгө оруулалт худалдан авалтын техникийн тодорхойлолтууд дээр ажиллаж байна.
- БОАЖЯ-ны ойн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн 2019 онд манай аймагт хийх ажлынхаа талаар газар дээр нь ирж үзэн танилцаж санаа бодлоо солилцон нөхцөл байдлыг тодорхойлоод явсан.
- ТХГН-ийн иргэдийн зүй зохисгүй дадал зуршилын улмаас бий болсон их хэмжээний хүнсний зүйлсийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.



СДОАнгийн зургаан албан хаагч албан хаагч хамтран Хэрлэн голын бургасан ойн санд үхжсэн хэсэг болон унанги хаягдлыг цэвэрлэх ажлыг гүйцэтгэлээ.



Хянасан: БОАЖГ-ын дарга

Д.Мөнх-Эрдэнэ

Мэдээ гаргасан: Мэргэжилтэн

С.Сувдмаа